

# “МОНГОЛ УЛС, БНСУ-ЫН ХООРОНД ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭР БАЙГУУЛАХ БОЛОМЖ, ХЭТИЙН ТӨЛӨВ

Г.Уранбайгаль

Стратегийн Судалгааны Хүрээлэн

Судлаач

**М**онгол Улс 1997 онд Дэлхийн Худалдааны байгууллагад (ДХБ) гишүүнээр элсэж, гадаад худалдааны харьцангуй нээлттэй, чөлөөт бодлого баримталсаар ирсэн юм. Монгол Улсын эдийн засгийн хөгжил, чадамж нэмэгдэхийн хэрээр экспортын зах зээлээ өргөтгөн тэлэх асуудалд анхаарлаа хандуулах болов. Энэ үүднээс, 2014 оны 7 дугаар сард Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Японд айлчилж, Монгол-Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн (ЭЗТХ) агуулгыг үндсэнд нь тохиролцсон билээ.

Монгол Улсын худалдаа, эдийн засгийн гол түнш БНХАУ, ОХУ, БНСУ болон Япон зэрэг ЗХА-ийн улстай хоёр талт Чөлөөт Худалдааны хэлэлцээр<sup>1</sup> (ЧХХ) байгуулснаар талуудын эдийн засагт гарах өөрчлөлтийг ерөнхий тэнцвэрийн загвар ашиглан шинжилж үзэхэд, тэдгээрийн Монгол Улсын макро эдийн засгийн түвшинд үзүүлэх нөлөөлөл бараг байхгүй гэх судалгаа гарчээ.<sup>2</sup> Монголын эдийн засаг, гадаад худалдааны эргэлтийн өнөөгийн бүтцийг авч үзвэл энэ дүгнэлт бодит байдалтай бүрэн нийцэж байна.<sup>3</sup> Гадаад худалдааны эргэлт ДНБ-ийн хэмжээнээс давсан үзүүлэлттэй байгаа ч нийт экспортын 90 гаруй хувийг эзэлж буй уул уурхай болон мал аж ахуйн түүхий эд нэмүү өртөг багатай бараа бүтээгдэхүүн учир түнш орнуудад ихэвчлэн татвараас чөлөөлөгдсөн байдаг. Нөгөөтэйгүүр, импортын бараа бүтээгдэхүүнд ноогдуулж буй Монгол Улсын тарифын хэмжээ харьцангуй бага байдаг.<sup>4</sup> Энэ нь Монголын гадаад худалдаанд албан бус ЧХХ хэдийнээ үйлчилж байгааг илтгэж буй юм.

<sup>1</sup> Аливаа улс орон зах зээлээ нэмэгдүүлэх, хоорондын худалдаа хөрөнгө оруулалтын хувь хэмжээгээ нэмэгдүүлэх үүднээс хоёр талын болон тодорхой бүс нутгийг хамарсан ЧХХ-г байгуулдаг. Тус хэлэлцээрт оролцогч талууд харилцан тарифаа тэглэх эсвэл эрс бууруулахын зэрэгцээ худалдаа, хөрөнгө оруулалтын бусад саад тотгороо арилгаж, зах зээлээ нээснээр харилцан ашигтай худалдаа хийх илүү өндөр боломж бүрдэх талтай аж.

<sup>2</sup> 2005 онд худалдааны гол түнш орнууд болох БНХАУ, ОХУ, Япон, БНСУ, АНУ-г сонгон авч, Монгол Улс ЧХХ байгуулах боломжийг эрэлхийлэх судалгааны ажлыг эхэлсэн юм. Улмаар АСЕМ, АПЕК, АСЕАН-тай тус хэлэлцээрийг байгуулах зорилттой ажиллаж байна. “Options for Mongolia for the Formation of Bilateral Free” Christian Helmers, 2006

<sup>3</sup> Зүүн хойд Азийн орнуудтай ЧХХ байгуулснаар Монгол Улсын эдийн засагт гарах нөлөөллийн шинжилгээ” 2014 он Ш.Энхбаяр, Т.Накажима, Стратегийн судалгаа сэтгүүл 2014/3,

<sup>4</sup> Монгол Улсын импортын тариф 4.6 хувь байгаа явдал бусад улсын стандарттай харьцуулахад хэт доогуур үзүүлэлттэй байгаа бөгөөд энэ тариф гадаадын экспортлогчдод таатай нөхцөлийг бий болгож байгаа.

Гэхдээ ЧХХ байгуулснаар нэхмэл, оёдол, арьс шир, мах махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийн экспортын хэмжээ нэмэгдэж, улмаар ажлын байрыг нэмэгдүүлэх гол эх үүсвэр болох боломжтой. Гэвч эдгээр бараа бүтээгдэхүүний нийт экспортын дүнд эзлэх хувь тун бага тул ДНБ-д төдийлөн нөлөө үзүүлэхгүй. Тиймээс Монгол улс аливаа ЧХХ-ээс бодит үр ашиг хүртэхийн тулд экспортын чиглэлийн, нэмүү өртөг өндөртэй үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх шаардлагатай болж байна.

### **Монгол-БНСУ-ын Чөлөөт Худалдааны хэлэлцээрийн явц, үр ашиг:**

Хөгжиж буй орнуудын ЧХХ байгуулсан туршлагыг судалж үзвэл бага орлого бүхий орнууд хоорондоо хэлэлцээр байгуулсан тохиолдолд шилжилтийн ашиггүй байдлыг нэмэгдүүлж, бодит орлого багасдаг байна. Харин өндөр орлого бүхий орнуудтай ЧХХ байгуулах явдал хөгжингүй улсын орлогын түвшнийг өндөр хөгжилтэй орны орлогын түвшин рүү татах хандлага ажиглагддаг. Тиймээс Монгол Улс ЧХХ байгуулахдаа “хөгжиж буй орон-хөгжиж буй орон” бус “хөгжиж буй орон- өндөр хөгжилтэй улс” гэх стратегийг баримтлах нь зөв болно.<sup>5</sup>

Энэ үүднээс Монгол Улс БНСУ-тай ЧХХ байгуулснаар эдийн засагт гарах өөрчлөлтийн судалгааг анх 2006 онд хийсэн бөгөөд 2016 онд Ерөнхийлөгч Пак Гын Хэ уг хэлэлцээрийг байгуулах яриа хэлэлцээг эхлүүлэхээ мэдэгдэв.<sup>6</sup> Хоёр улсын эдийн засгийн харилцааг тоогоор илэрхийлэхэд бусад орнуудаас бага хэмжээтэй ч богино хугацаанд тасралтгүй өсч, ажиллах хүчин, соёлын салбарын хамтын ажиллагаа амжилттай явагдах замаар харилцаа, хамтын ажиллагаагаа гүнзгийрүүлж байна. Түүнчлэн талууд байгалийн баялаг, эрчим хүчний баталгаатай байдал, Европ руу экспорт хийх боломжийг харгалзан үзэж, БНСУ-аас Монгол улс руу технологи нэвтрүүлэх, боловсон хүчин бэлтгэх зэргээр хэрэгцээгээ харилцан нөхөх шинжтэй хамтын ажиллагааг эрэлхийлж байгаа юм.

<sup>5</sup> “Монгол Улсын Чөлөөт Худалдааны Хэлэлцээр байгуулах үйл явц буюу БНСУ-тай ЧХХ байгуулах боломж” Г.Мөнхсайхан, Шим И Соб

<sup>6</sup> Түүнчлэн айлчлалын хүрээнд олон талт худалдаа, хөрөнгө оруулалт, дэд бүтцийн нийт 4.49 тэрбум ам.долларын 20 орчим гэрээ хэлцэлийг үзэглэсэн байна. БНСУ-ын Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч Чён Ва Дэ “Ёнхап” агентлаг

## Хүснэгт 1. ЧХХ байгуулах явц

| №  | Чөлөөт Худалдааны хэлэлцээрийг байгуулах явц       | Тайлбар  |
|----|--|--|
| 1. | Дотоодлоо хэлэлцэн шийдвэр гаргах                  | Тухайн улстай хэлэлцээр байгуулах эсхийг дотоодлоо хэлэлцэн тохирч, шийдвэр гарган хэлэлцээр байгуулагч талд санал тавих |
| 2. | Хэрэгцээгээ тохирох                                | Хэлэлцээрийг байгуулагч талууд хоорондын хэрэгцээгээ бүрэн зөв тодорхойлох   |
| 3. | ЗГ хоорондын яриа хэлэлцээ                         | Хоёр талын зорилт хийгээд стратегийг тодорхойлох   |
| 4. | Хамтарсан судалгааны баг, ажлын хэсэг байгуулах    | Хэлэлцээрийн үр нөлөө, хэтийн хандлагыг тодорхойлох  |
| 5. | Хэлэлцээрийн агуулганд санал нэгдэх, гэрээ бэлтгэх | Харилцан хэлэлцэн, хөтөлбөрөө тохирох ба хэлэлцээрийг бэлтгэхдээ ОУ-ын болон үндэсний эрх зүйг зөрчөөгүй эсэх            |
| 6. | Үзэглэх  | Хэлэлцээрийг байгуулагч ихэнх улсууд албан айлчлал, дээд хэмжээний уулзалтын үеэр үзэглэх нь бий.                        |
| 7. | Парламентаар батлуулах                             | Хэлэлцээр хэрэгжиж эхлэх явц   |

*Эх сурвалж: "Options for Mongolia for the Formation of Bilateral Free" Christian Helmers*

Сүүлийн жилүүдэд хоёр орны экспорт импортын барааны төрөлд жинтэй өөрчлөлт ажиглагдаагүй, тогтмол байдлыг хадгалсан шинжтэй байна. Хоёр орны импортын барааны татварын хэмжээг харьцуулахад манай улсын импортын татварын хэмжээ 4.2 хувь буюу тун бага хэмжээтэй байгаа бол БНСУ-ын хувьд 8.33 хувь буюу харьцангуй өндөр байна.

## Хүснэгт 2. Монголд ноогдуулж буй БНСУ-ын татварын хэмжээ, салбараар

| Татварын нэрс                                 | Дундаж | Монголд |
|---|--------|---------|
| Нийт импортын татвар                          | 7.1%   | 9.7%    |
| ХАА-н гаралтай бүтээгдэхүүний импортын татвар | 34.9%  | 34.8%   |
| Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импортын татвар  | 6.2%   | 7.2%    |

*Эх сурвалж: "Эдийн засгийн интеграц: Чөлөөт худалдааны хэлэлцээрийн экспортын бүтцэд үзүүлэх нөлөө" Р.Батмэнд, Б.Хулдорж*

БНСУ-ын зүгээс Монгол улсад ноогдуулж байгаа татварын хэмжээг үйлдвэрлэлийн салбараар харьцуулбал харьцангуй өндөр татвартай байна. БНСУ-ын татварын тогтолцоо шат дараалсан нарийн бүтэцтэй байх ба Монгол улсын экспортын гол бүтээгдэхүүн, ХАА-н гаралтай бараа бүтээгдэхүүн 34.8 хувийн татвар<sup>7</sup> ноогдуулж байгаа явдал Монгол улсын экспортод чухал нөлөөтэй юм. Харин БНСУ манай улстай ижил төстэй бараа экспортлодог Филиппин, Хятад зэрэг улстай худалдаа хийхдээ худалдааны хөнгөлөлтийн ерөнхий систем<sup>8</sup> болох GSTP хэлэлцээрт тулгуурлан татварын хөнгөлөлт

<sup>7</sup> БНСУ дотоодын ХАА-н бүтээгдэхүүнийг импортын бараанаас хамгаалах үүднээс өндөр татварын хориг тавьдаг бөгөөд цаашид энэ импортын татварын хэмжээг буурна гэж найдах өрөөсгөл юм.

<sup>8</sup> GSTP- Global System of Trade Preferences among Developing Countries хэлэлцээрт үндэслэсэн Худалдааны хөнгөлөлтийн ерөнхий систем бөгөөд сүүлийн жилүүдэд Филиппин, Шри-Ланка, Энэтхэг зэрэг улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг БНСУ-д импортлоходоо энэ хэлэлцээрийг ашиглаж байна. Уг хэлэлцээ нь 77 бүлийн хөгжиж буй орнууд хоорондын

Үзүүлдэг байна.

Хүснэгт3. ЧХХ-ийн байгуулснаар Монгол Улсын ДНБ-ний бодит өөрчлөлт, %

| ЧХХ-ийн түнш орон | ДНБ-ний бодит өөрчлөлт |
|-------------------|------------------------|
| БНХАУ             | 0.0003                 |
| ОХУ               | 0.0198                 |
| БНСУ              | -0.0215                |
| Япон              | -0.0236                |

*Эх сурвалж: Зүүн хойд Азийн орнуудтай ЧХХ байгуулснаар Монгол Улсын эдийн засагт гарах нөлөөллийн шинжилгээ, Ш.Энхбаяр, Т.Накажима*

Дээрх хүснэгтээс харвал, Монгол улсын эдийн засгийн чадамжийн зөрүүнээс үүдэн Монгол улс, БНСУ ЧХХ байгуулахдаа эдийн засгийн ЧХХ (Economic plus FTA) бус стратегийн ЧХХ (Strategic FTA) байгуулах боломжтой юм. Талууд тус хэлэлцээрийг байгуулсан тохиолдолд богино хугацааны үр дүнгээс (short-run effect) илүү урт хугацааны үр дүнг (long-run effect) илүүд үзэх хандлагатай байна. Түүнчлэн Монгол улсын хувьд ЧХХ байгуулахдаа хөнгөлөлттэй худалдааны хэлэлцээр зэрэг барааны худалдаанд чиглэсэн хэлэлцээрээр эхэлж, урт хугацааны стратеги болох бараа үйлдвэрлэлд чиглэсэн гэрээ хэлцэлийг байгуулахыг зорих нь зүйтэй. Тухайлбал, Монгол улс, БНСУ-ын хувьд бараа үйлчилгээний чөлөөт худалдааг голлосон хэлэлцээр байгуулахаас илүүтэй БНСУ-БНЭУ хооронд байгуулсан олон талт эдийн засгийн түншлэлийн хэлэлцээртэй (СЕРА: Comprehensive Economic Partnership Agreement) төстэй хэлэлцээр байгуулах илүү ач холбогдолтой болно.

---

бараа бүтээгдэхүүний худалдаа, хамтын ажиллагааг дэлхий нийтийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн хүрээнд хөгжүүлэх зорилттой хэлэлцээр юм.

## Дүгнэлт

Монгол улсын эдийн засаг, гадаад худалдааны өнөөгийн бүтэцтэй холбоотойгоор тус улсаас бусад оронтой ЧХХ байгуулахын ач холбогдол макро эдийн засгийн түвшинд бараг мэдрэгдэхгүй ч ЧХХ байгуулснаар боловсруулах үйлдвэрлэлийн голлох салбар болох нэхмэл, оёдол, арьс шир, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээ өсөн улмаар ажлын байр нэмэгдэх боломж бүрдэнэ.

Монгол улс, БНСУ-ын хооронд ЧХХ байгуулснаар хоёр орны худалдаа 6.1 дахин өсч<sup>9</sup> энэхүү хэлэлцээрээс хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа нэмэгдэн харилцан ашиг олох боломжтой. Гэвч хоёр орны худалдааны эргэлтэнд татварын болон татварын бус саад бэрхшээл оршиж байна. Түүнчлэн хоёр улс ЧХХ байгуулахын өмнө гадаад худалдааны эргэлтээ сайжруулан ялангуяа тээвэрлэлтийн зардлыг бууруулах, Монголын хувьд худалдааны хялбарчлалаа сайжруулах, экспортлож болох барааны төрлийг нэмэгдүүлэх шаардлагатай юм.

<sup>9</sup> Хоёр улсын ДНБ 1% өсөхөд, худалдаа 22.1% дахин өсөх үзүүлэлттэй байгаа бол нэг хүнд ноогдох ДНБ 1%-нар өсөхөд худалдааны эргэлт 64.1% өсөх магадлалтай аж. Харин хоёр улсын газар нутгийн зай худалдааны эргэлтийг 43%-нар бууруулж, БНСУ-ын импортын татвар нь худалдааг 82.7% багасгах таамаглалыг 2006 оны “Эдийн засгийн интеграц: Чөлөөт худалдааны хэлэлцээрийн экспортын бүтцэд үзүүлэх нөлөө” судалгаанд дурдсан байна.

## Дүгнэлт

Монгол улсын эдийн засаг, гадаад худалдааны өнөөгийн бүтэцтэй холбоотойгоор тус улсаас бусад оронтой ЧХХ байгуулахын ач холбогдол макро эдийн засгийн түвшинд бараг мэдрэгдэхгүй ч ЧХХ байгуулснаар боловсруулах үйлдвэрлэлийн голлох салбар болох нэхмэл, оёдол, арьс шир, мах махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортын хэмжээ өсөн улмаар ажлын байр нэмэгдэх боломж бүрдэнэ.

Монгол улс, БНСУ-ын хооронд ЧХХ байгуулснаар хоёр орны худалдаа 6.1 дахин өсч<sup>9</sup> энэхүү хэлэлцээрээс хоёр орны эдийн засгийн хамтын ажиллагаа нэмэгдэн харилцан ашиг олох боломжтой. Гэвч хоёр орны худалдааны эргэлтэнд татварын болон татварын бус саад бэрхшээл оршиж байна. Түүнчлэн хоёр улс ЧХХ байгуулахын өмнө гадаад худалдааны эргэлтээ сайжруулан ялангуяа тээвэрлэлтийн зардлыг бууруулах, Монголын хувьд худалдааны хялбарчлалаа сайжруулах, экспортлож болох барааны төрлийг нэмэгдүүлэх шаардлагатай юм.

<sup>9</sup> Хоёр улсын ДНБ 1% өсөхөд, худалдаа 22.1% дахин өсөх үзүүлэлттэй байгаа бол нэг хүнд ноогдох ДНБ 1%-нар өсөхөд худалдааны эргэлт 64.1% өсөх магадлалтай аж. Харин хоёр улсын газар нутгийн зай худалдааны эргэлтийг 43%-нар бууруулж, БНСУ-ын импортын татвар нь худалдааг 82.7% багасгах таамаглалыг 2006 оны “Эдийн засгийн интеграц: Чөлөөт худалдааны хэлэлцээрийн экспортын бүтцэд үзүүлэх нөлөө” судалгаанд дурдсан байна.

## Ашигласан бүтээл:

1. “Эдийн засгийн интеграц: Чөлөөт худалдааны хэлэлцээрийн экспортын бүтцэд үзүүлэх нөлөө” 2011 он Р.Батмэнд, Б.Хулдорж, Д.Нямцэрэн, Н.Отгонсайхан, Монголын худалдаа: Бодлого, Шинэтгэл ОУ-ын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл
2. “Зүүн хойд Азийн орнуудтай ЧХХ байгуулснаар Монгол Улсын эдийн засагт гарах нөлөөллийн шинжилгээ” 2014 он Ш.Энхбаяр, Т.Накажима, Стратегийн судалгаа сэтгүүл 2014/3, The Northeast Asian Economic Review, ERINA 2013/1
3. Монгол Улсын Чөлөөт худалдааны хэлэлцээрийн үйл явц буюу БНСУ-тай ЧХХ байгуулах боломж” 2011он Г.Мөнхнасан, Шим И Соб, Монголын худалдаа: Бодлого, Шинэтгэл ОУ-ын эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл
4. “Зүүн хойд Азийн чөлөөт худалдааны хэлэлцээр ба Монгол” 2007 он Р.Амаржаргал, Нээлтгэй нийгэм форум
5. “Options for Mongolia for the Formation of Bilateral Free” Christan Helmers
6. Impacts of Mongolian FTAs with the Countries in Northeast Asia: CGE Analysis with the GTAP 8 Data Base-Sh.Enkhbayar, Tomoyoshi Nakajima, ERINA
7. Mongolia in the region: time for economic foreign policy, Julian Dierkes
8. <http://www.eastasiaforum.org/2014/03/23/mongolia-in-the-region-time-for-economic-foreign-policy/>
9. ROK-Mongolia Free Trade Agreement, By Kang Hyun-kyung
10. [http://www.koreatimes.co.kr/www/news/nation/2015/03/176\\_174333.html](http://www.koreatimes.co.kr/www/news/nation/2015/03/176_174333.html)
11. South Korea, Mongolian Agree to Pursue EPA, Jung Suk-yeec
12. <http://www.businesskorea.co.kr/english/news/politics/15254-korea-mongolia-free-trade-s-korea-mongolia-agree-pursue-epa>
13. Japan-Mongolia FTA and mineral resources, Dr.Nobuta Iwata [http://www.wto.aoyama.ac.jp/file/opinion12\\_iwata.pdf](http://www.wto.aoyama.ac.jp/file/opinion12_iwata.pdf)